

Инновац, технологи дамжуулалт, гарааны компани хариуцсан ахлах мэргэжилтэн, Баатар Туул

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь	
	1	2	3	4	5	6	7	
1.1. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах								
1	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг шинэчлэн батлуулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	ЗГ-ын 2015 оны “Журам батлах тухай” 267 дугаар тогтоол	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төсөлд санал авч, Засгийн газраар батлуулахаар хүргүүлсэн байна.	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төсөлд санал авч, Засгийн газраар батлуулахаар хүргүүлсэн байна.	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төслийг боловсруулсан. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль 10.1.6.д, Инновацийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу хоёр хуулийн давхардал, журмын хамрах хүрээний зөрүүтэй байдал үүссэн тул Хууль, эрх зүйн хэлтэстэй зөвлөлдөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай журмын төслийг хэлэлцэн, санал авахаар тогтсон. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	80%

2	Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж урамшуулах журмыг шинэчлэн батлуулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	2021 оны "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж, урамшуулах журам"	Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журмыг шинэчлэн батлуулсан байна.	Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулсан. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудсанд журмын төслийг нээлттэй байршуулж 2025.10.15-аас 2025.11.14-ны өдрүүдэд санал авсан. https://med.gov.mn/post/169353 . Журмыг Сайдын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулж, цахим системд холбогдох удирдлагаар хянагдаж байна. 2025.12.31-ний өдрийн дотор батлагдана. Хавсралт: 1 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Аж ахуй нэгж байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эрх зүйн орчиныг бий болгох чиглэлээр шаардлагатай хууль, тогтоомж, баримт бичгийн төсөл боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	Хууль, тогтоомж, баримт бичгийн төслийг батлуулахаар хүргүүлсэн байна.	Аж ахуй нэгж байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бий болгох чиглэлээр Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15, 22 дугаар зүйлд нэмэлт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнд: "15.9. Жилийн борлуулалтын орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш аж ахуй нэгжийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтын зардлыг 200 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцно."; "22.16. 2.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуй нэгжийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын зардлын 50 хувийг тухайн жилд оногдсон албан татвараас хасаж тооцно хэрэв татварын хөнгөлөлт нь тухайн жилийн татварын үүргээс их байвал илүү гарсан хэсгийг дараагийн 5 жилийн татвараас шилжүүлэн хасах эсвэл буцаан олгоно." гэж нэмэх саналыг тус тус хүргүүлсэн. Ингэснээр Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.2-т заасан "Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх бөгөөд уг асуудлыг татварын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн заалт хэрэгжих боломж бүрдэнэ. Татварын багц хуулийн төсөлд тусгуулахаар Макро эдийн засгийн бодлогын газарт хүргүүлж, Сангийн яаманд хүргэх нэгдсэн саналд тусгасан. Хавсралт: 1 файл		
4	Дээд боловсролын сургалтын байгууллага, музейг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг	Батлуулсан баримт бичгийн тоо	2007 оны "Үнэлгээний үзүүлэлт батлах тухай" 463 дугаар тушаал	Дээд боловсролын сургалтын байгууллага, музейг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах арга хэмжээг	Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/34 дүгээр тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллага, музейг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт"-ийг шинэчлэн батлуулсан. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.			хэрэгжүүлсэн байна.	хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллан, шалгуур үзүүлэлтийг хангасан Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг эрдэм шинжилгээний байгууллагад хамааруулж, судалгааны үндсэн чиглэлийг тогтоов. Хавсралт: 2 файл		
5	"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд "Шинжлэх ухаан, технологийн салбарт баримтлах" чиглэлийн төслийг боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд "Шинжлэх ухаан, технологийн салбарт баримтлах" чиглэлийн төслийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулж, оролцогч талуудын саналыг тусган хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд "Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун" бодлогын чиглэлийг Үндэсний түвшний 1 үр дүн, салбарын 2 үр дүн, ТЭЗ-ийн 3 үр дүн, хөтөлбөрийн 7 үр дүн, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлон боловсруулсан. Мөн Шинжлэх ухаан, технологийн салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээг тодорхойлсон. - "МУ-ыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийн төслийг боловсруулахад ЭЗХЯ-ны харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, ШУА, их сургуулийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Ажлын хэсгийг байгуулж, санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг тусгах ажлыг зохион байгуулсан. - "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					<p>чиглэл"-ийн төслийг Шинжлэх ухааны академийн төрөлжсөн 2 академи, 6 салбарын Бага чуулган, Их чуулганы хуралд хэлэлцүүлээ. Баримт бичгийн төсөлд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдаас хэл зүй, найруулгын санал, зөвлөмж гаргуулан баримт бичгийг сайжруулан эцэслэж, холбогдох газар нэгж, дээд байгууллагад хүргүүлсэн. -УХОХ-т санхүүжилт шаардлагатай 1 арга хэмжээ, ТЭЗҮ шаардлагатай 3 арга хэмжээний саналыг боловсруулан хүргүүлсэн. Санхүүжилт шаардлагатай 1 арга хэмжээ батлагдсан.</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
--	--	--	--	--	--	--

3.1. Шинжлэх ухааны судалгаа, дэвшилтэт технологи, инновацыг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өсөлтийг дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, шинжлэх ухааны судалгааны төслийн бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангах;

6	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2025 оноос эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион	2025 онд хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн тоо	Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" А/497 дугаар тогтоол	Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжилтийг хангасан байна.	Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу 2025 оноос эхлэн хэрэгжих суурь, технологийн туршилт зүгшрүүлэлтийн төсөл болон хамтарсан төслийн мэдүүлгийг ШУТС-ийн цахим системээр авч, шинжээчийн олонхын санал дүгнэлт авсан нийт 71 төслийг шинжлэх ухааны 7 салбар чиглэлээр сонгон шалгаруулах	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--	---	---	---	--	------

	байгуулалтаар ханган ажиллана.				ажлыг зохион байгуулж, Мэргэжлийн хорооны хурлаар хэлэлцүүлж, 2025 онд шинээр хэрэгжих нийт 60, үүний 51 нь суурь судалгааны, 9 нь технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл хэрэгжихээр шийдвэр гаргасан байна. Хавсралт: 1 файл		
7	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг удирдлагаар хангаж ажиллана.	Барилгын ажлын гүйцэтгэлийн явц, хувиар	2024 оны эцсийн байдлаар барилгын гүйцэтгэлийн хувь 45%-д хүрсэн.	Цогцолборын барилгын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын баригдахаар төлөвлөгдсөн 7 объектоос 27,000 м2 ашиглалтын талбай бүхий лабораторийн 3 барилга болон тусгай зориулалтын агуулахын барилгууд болон оффисын хоёр барилгын угсралтын явц 80 гаруй хувьтай явагдаж байгаа бөгөөд цогцолбор нь бүхэлдээ 2026 онд ашиглалтад орно. Тус цогцолборт Шинжлэх Ухааны Академи түүний харьяа эрдэм шинжилгээний 16 хүрээлэн, Анагаах ухаан хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн. ЭЗХЯ болон ШУА-ын хамтарсан ажлын хэсэг ажиллан лабораторийн 3 барилгыг хүлээн авсан. Одоогийн байдлаар тус цогцолборын эхний ээлжийн барилгууд ашиглалтад орж нийт 7 хүрээлэнгийн 500 гаруй судлаачид таатай орчинд судалгааны ажлаа хийж эхлээд байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Хавсралт: 1 файл			
8	Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтсан "Шинжлэх ухаан, технологи-инновац-2025" арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр тогтмол	"Шинжлэх ухаан, технологи-инновац-2025" арга хэмжээг зохион байгуулсан байна.	Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 204 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.5 дахь заалтад заасны дагуу 2025 оны шинжлэх ухааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/56 тоот тушаалаар баталсан. "Шинжлэх ухаан – 2025" баярын арга хэмжээг 2024 оны 12-р сарын 05-ны өдөр салбарын 400 гаруй албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр салбартаа үр бүтээлтэй ажилласан салбарын албан хаагчдад төрийн дээд одон медаль болон Залуу судлаачдын грант, Докторын дараах сайдын нэрэмжит грантыг гардуулсан. Хавсралт: 2 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%	

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин

782

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ		Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад цахим, танхимаар хамрагдах	Удирдлагын академийн Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	2024 онд Яамны Мэдээллийн цаг, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтуудад тухай бүр хамрагдаж байсан.	-	- 2025.03-2025.06 сард Удирдлагын академийн "ТАХ-ийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт"-д хамрагдаж төгссөн. - Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас хамтран зохион байгуулсан "Шинжлэх ухаан, технологи, инновацын паркийн бодлого, туршлага" сэдэвт үндэсний сургалт 2025 оны 4 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд хамрагдаж сертификат авсан.Тус сургалтад бодлого боловсруулагчид, шинжлэх ухаан, технологийн парк, бизнес инкубатор, хамтын оффис, технологи дамжуулах төвийн төлөөлөл, судлаачид, гарааны бизнес эрхлэгч нар болон олон улсын мэргэжлийн зөвлөхүүд, Шинжлэх ухааны паркийг амжилттай хөгжүүлж буй улс орны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					төлөөлөл зэрэг 40 гаруй төлөөлөл хамрагдсан. - Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ эрх авах шалгалтад тэнцэн, сертификат авсан. Хавсралт: 2 файл		
2	Төрийн албан хаагчийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцох	Төрийн албан хаагчийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцох	-	Төрийн албан хаагчийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцсон байна.	-Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн санаачилгаар орон даяар зохион байгуулж буй "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" сэдэвт Нийслэлийн бүсийн зөвлөгөөнд 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр хамрагдсан. Зөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, 9 дүүрэг болон яам, агентлаг, тэдгээрийн харьяа төрийн байгууллагын төлөөлөл 1200 албан хаагч оролцсон. - ТАЗ-ийн 30 жилийн ойд зориулан 3 үе шатаар зохион байгуулсан "ТӨРИЙН АЛБАНЫ РЕФОРМ-БИДНИЙ ШИЙДЭЛ" төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд "ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛД БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА, ИННОВАЦЫГ АШИГЛАХ НЬ" сэдэвт бүтээлээр яамны ахлах	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				шинжээч С.Манлайдулам, шинжээч О.Золзаяа, ахлах мэргэжилтэн Л.Мөнхтуяа нарын хамтаар амжилттай оролцон, шилдэг 10-т шалгарсан.	
--	--	--	--	---	--



ХЯНАСАН:

Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батболд Мөнхтөр /...../

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Инновац, технологи дамжуулалт, гарааны компани хариуцсан ахлах мэргэжилтэн, Баатар Туул /...../

Огноо: 2025.12.15